

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр, Мягмар гараг*

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-20

---

<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	4
<i>2.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	4-18
<i>3. “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” /“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/ Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	18-20

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
06 дугаар сарын 13-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 33 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн;

Чөлөөтэй: Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Цэрэнпунцаг, Н.Ганибал.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн,

Санхүү, төсвийн судалгааны бодлогын газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, мөн хэлтсийн мэргэжилтэн Х.Дэнсмаа, Н.Уранцэцэг, П.Энхманлай, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар тус тус танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, О.Цогтгэрэл, Т.Доржханд, Д.Өнөрболор, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “9.1.112.Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг” гэснийг “Төв замуудын гэрлэн чимэглэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 12  
Бүгд: 13  
7.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.** “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” /“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/ Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын Төслийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ш.Маргад нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” /“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/ Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаалагчид нь буцаах нь зүйтэй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 01 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 34 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
12 цаг 33 минут.

### **ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн нэрсийг танилцуулъя. Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Багаагийн Баттөмөр гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн, Жамбалын Ганбаатар ирсэн, Болдын Жавхлан сайд ирсэн байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн ирсэн, Чинбатын Ундрам гишүүн ирсэн, Одонгийн Цогтгэрэл ирсэн, Содномын Чинзориг ирсэн, Төмөртоогогийн Энхтүвшин ирсэн. Хуралдаанд ирсэн гишүүдийн, хуралдаанд ирсэн гишүүдийн нэрсийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны ирц бүрдсэн тул Байнгын хорооны хуралдааныг Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 3 асуудал хэлэлцэнэ. Нэгд, Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл, 2.Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 3.Улсын Их Хурлын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Иргэний нисэхийн тухай хуулийн**

*шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/*

1 дүгээр асуудал. Иргэний нисэхийн тухай хуулийн төслийг, төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Байнгын хорооны тогтоолын төсөл. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

Нэг.Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийг төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ, ажлын хэсгийн гишүүдэд Б.Баттөмөр гишүүн, Н.Ганибал гишүүн, М.Оюунчимэг гишүүн, Б.Энхбаяр гишүүн.

Хоёр.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг Ж.Бат-Эрдэнэд даалгуулсугай. Эдийн засгийн байнгын хорооны даргын үүрэг гүйцэтгэгч Ж.Бат-Эрдэнэ гэсэн байна. Саналтай гишүүд байна уу? Тогтоолын төсөлтэй холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Тогтоолын төсөл, санал хураалт 80 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ. Энэ санал хураалт явуулж дууслаа.

12.34 цаг

**Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны**

**төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Дараагийн асуудалд оръё. 2 дугаар асуудал дээр танилцуулга Эдийн засгийн байнгын хороо юу, Эдийн засаг хөгжлийн сайд ирээгүй байгаа учир 3 дахь асуудал руу орчихъё. Төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Улсын Их Хурлын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг нээе.

**Б.Жавхлан:** Эрхэм Байнгын хороон дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7,9 хувиар өсөж, гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3,8 тэрбум долларт хүрч сайжраад байна. Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй, иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого амьжиргааг дэмжих зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотгол төсөлд тусгалаа. Тухайлбал: 1.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан

өрхийн хүүхэд бүрд олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох. 2.Тэтгэврийн зөрүүний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх. Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх. 4.Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын сүлжээг өргөтгөх зэргээр нийслэлийн түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1,7 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлага 1,8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1,6 их наяд төгрөг буюу анх батлагдсан ДНБ-ий 2,6 хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөлөө.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Занданбат танилцуулна. Занданбат даргын микрофон. 3 дугаар, 3 номерын микрофон.

**Д.Занданбат:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2023 оны 6 дугаар сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781,9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34,5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371,4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37,2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589,5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2,6 хувь байхаар төлөвлөжээ. Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт дараах өөрчлөлтийг оруулсан байна.

СЗХ-ны дарга 2023 оны тодотголын төсөл 12,3 тэрбум, ҮСХ-ны дарга 20,9 тэрбум, БХБ-ын сайд 387,4 тэрбум, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 41,7 тэрбум, Зам, тээврийн хөгжлийн сайд 482,1 тэрбум, Эрчим хүчний сайд 256 аравны, 256 тэрбум, нийт дүнгээрээ 1 их наяд 200.4 тэрбум төгрөг байхаар байна, төсөвлөсөн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын нийт төсөв 15,8 тэрбум төгрөгөөр өсөхөд төрийн албан хаагчийн цалин хөлсний системийг шинэчлэн цалинг нэмэгдүүлэн тогтоосон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал өсөж байгаа нь голлон нөлөөлсөн байна.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал нь хандсанд баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа.  
Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг

танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Хүрэлбаатарын Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Санжаагийн Мөнгөнчимэг Сангийн дэд сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Доржсүрэнгийн Занданбат Монгол Улсын ерөнхий аудитор. Нөгөөдөх нь хэн ирсэн гэнэ вэ? Дэлгэрийн Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Баасансүрэнгийн Алимаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Нарантуяагийн Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Байгалмаагийн Одонтуяа Сангийн яамны Өрийн удирдлагын газрын хэлтсийн дарга, Жамъяншиаравын Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Жаргалсайханы Төгөлдөр Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Энхболдын Цолмон Сангийн яамны Төсвийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, Хүрэлрагчаагийн Дэнсмаа Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Ням-Осорын Уранцэцэг Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Пүрэвжавын Энхманлай Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Энхбаярын Цолмон Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс ирүүлснийг та бүхэнд ирүүлсэн

байгаа, материалыг өгсөн байна. Ингээд хууль санаачлагчаас болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Ундрам гишүүнээр тасалъя. Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Эдийн засагт бас тодорхой хэмжээний өөрчлөлтүүд гарч төсөв маань тодорхой хэмжээний бас хуримтлалтай болж төсвийн тодотголыг хийж байна. Энэ танилцуулга дотор бол сүүлийн 20 сарын хугацаанд гадаад нөхцөл байдлаас шалтгаалж инфляц 10-аас дээш хувиар өссөн гэж ингэж танилцуулсан байгаа. Би бол энэтэй санал нийлэхгүй байна. Бүгдийг нь гадаад руу чихэж болохгүй шүү дээ. Инфляцын чинь бас зонхилох хэсэг нь мах, гурил гээд Монголчуудын үндсэн хэрэглээ явж байгаа шүү дээ. Тэгээд бүгдийг нь ингээд гадаад руу чихчих юм уу? Нийлүүлэлтийн шинж чанартай Засгийн газрын өөрийнх нь хариуцах юмнууд байж байгаа шүү дээ. Засгийн газар их мундаг ажиллаад гадаадаас шалтгаалаад инфляц 10-аас дээш болоод байна гэж би ойлгохгүй байгаа. Энд хариулт авъя.

2 дугаарт нь энэ төсвийн нийт зарлагын чинь 79 орчим хувь нь юу байгаа шүү дээ. Нөгөө урсгал зардал. Энэ тодотгол хийгээд энэ зарлагын хэмжээ багасаж байна уу, үгүй юү? Бид чинь цахим болж байна гээд л маш их хэмжээний л ийм реклам хийгээд байгаа шүү дээ. Цахим болох тутам зардал хэмнэгдэх ёстой. Ийм байна уу, үгүй юү гэсэн нь ийм байгаа.

Ер нь цаашидаа тэгээд энэ 24 оноос эхлээд инфляцтайгаа уялдуулж цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр юу хийж, юу бодож байгаа вэ? Энэ хаана хаанаа хариуцлагатай байх ёстой л доо. Ард иргэд бол төр засгаасаа бол тодорхой хэмжээний итгэж байгаа бидэнд. Тэгэхээр бол инфляц эрэлтийн ч бай, нийлүүлэлтийн ч бай шинж чанартай инфляцыг бол бид удирдах ёстой. Эндээ

тохирсон бодлого явуулж бид энэ инфляцтай уялдуулж цалин хөлсийг, тэтгэвэр тэтгэмжийг нэмэх ёстой. Энэ чиглэлд бас ийм байж чадах уу, үгүй юү гэж.

Дараагийн асуудал энэ Хэмнэлтийн хууль байгаа юм. Энэ бол Хэмнэлтийн хууль бол сайн хууль шүү. Энийг ер нь улам боловсронгуй болгож хэмнэх ёстой. Гэхдээ энэ дотор бол тэр тендертэй холбоотой заалт байгаа. Энийг 10 сарын 1 болгочхож байгаа юм. Нөхцөл байдлаас шалтгаалаад ингэж байгаа байх. Ер нь энэ Тендерийн хуульд өөрчлөлт оруулахгүй юу? Төсөв гэдэг бол тухайн ажлыг хийх бодит хязгаар шүү дээ. Тэгтэл тендер гэж зарлаад хамгийн муу, хамгийн чанаргүйг нь аваад шалгаруулдаг. Дархан-Уул аймагт тэр нэг спорт комплекс гээд 12, 3 жил барьж байна шүү дээ. Анхны төсөвт өртөг 3, 4 дахин нэмэгдчихсэн. Одоо хэзээ ашиглалтад орох нь тодорхойгүй. Хамгийн чанаргүй, хамгийн муу гүйцэтгэгчийг шалгаруулж байгаа юм. Тэр бусад орнуудад олон улсын турилага ямар байна вэ гэхээр тухайн жилүүдэд хийсэн ажлаар нь сайн гүйцэтгэгч, сайн нийлүүлэгчийг шалгаруулаад, тэгээд тэр төсөвт өртөгтэй нь уялдуулаад тодорхой хэмжээний хэмнэлтүүдийг тохиролцоод ингээд хийдэг турилагууд бий болчихжээ. Манайд бол юу гэхээр зэрэг тендер гэж зарладаг, нөгөөдөх нь тэгээд компаниуд ордог, зарим нь ордоггүй. Инфляц их өндөр байгаа учраас сүүлийн үед орохоо больчихсон. Ордог юмаа гэхэд хоорондоо маргалддаг, шүүхээр явдаг. Ингэсээр байгаад дуусдаг ийм байгаа.

Энэ нийслэлд IPO гаргаж байгааг бол 2 гараа өргөж дэмжиж байна. Энэ бол үнэхээр зөв зүйтэй эхлэл шүү. Хөрөнгийн захыг хөгжүүлэх, тэр бид нарын ярьдаг нөгөө нэг үр ашгийн муруй гээд юм ярьдаг шүү дээ. Тэгээд энэ, энэ тэрд бол маш их нөлөөтэй. Энийг ингээд цаашидаа энэ IPO гаргахаар банкнууд аваад банкнууд авчихдаг юм гэдэг ингэж суух биш, судалгаа гаргаад энэ Засгийн



газраас түвшинд ч гэсэн IPO гаргаж энэ хөгжлөө дэмжих ажилд ажилламаар байгаа юм. Энэ чиглэлд ямар бодол саналтай байгаа вэ?

**Ж.Бат-Эрдэнэ:** Жавхлан сайд хариулах уу? Жавхлан сайдын микрофон.

**Б.Жавхлан:** Манайх, манайх ч юу байх вэ дэлхий нийтээрээ энэ ковидын үед нийлүүлэлтийн инфляцтай явж ирсэн. Ингээд хилийн хоригууд тавигдсан, хилүүд бүгд нэгдсэн. Хилийн хориотой байдал нь тээвэр логистикийн хязгаарлагдмал байдлаас шалтгаантай инфляц бол үндсэндээ дууссан. Одоо бид эрэлтийн инфляц руугаа шилжсэн байгаа. Тийм учраас төсөв мөнгөний ийм хатуу бодлого үргэлжилж байна. Энэ удаагийн тодотголоор бол харин орлого, зарлага хоёр хоёулаа зэрэг нэмэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл үндсэн тэнцэл дээр бол өөрчлөлт ороогүй гэсэн үг.

Би 2 дахь асуултыг нь бас дайруулаад хариулчихлаа шүү. Инфляцын хувьд гадаад хүчин зүйлээс нөлөөлж байна гэдэг нь ийм юм хэлээд байгаа юм. Манай инфляцыг тооцдог 300 гаруй сагс, 300 гаруй бүтээгдэхүүнээс бүрддэг сагсны энэ Статистикийн ерөнхий газраас өгч байгаа тоо шүү. 51 хувь нь шууд гадаадаас импорттоор авдаг 51 хувь нь шүү бүр. 25 хувь нь орц байдаг гэж байгаа юм. Ингээд нийлээд бараг 75 хувийг нь бид нар гаднаас худалдаж авчирдаг. Энэ бол Статистикийн ерөнхий газраас гаргаж байгаа ийм факт тоо юм. Тэрийг хэлж байгаа л асуудал юм байгаа юм.

Тэр Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуульд шинэчилсэн найруулга Засгийн газраас өргөн бариад 3 дахь хэлэлцүүлэг дээрээ явж байгаа. Их Хурал яаж гарах бол яг Их Хурлын бүрэн эрхийн асуудал байгаа. Энэ таны саяын ярьсан зүйлүүд бас мөн хөндөгдөөд, өөрчлөлтүүд хийгдээд явж байгаа. Нийслэл IPO гаргана гэж та юу хэлсэн юм бол? Нийслэл Корпорэйт бонд бол гаргах гэж байгаа. Засгийн газрын хувьд тийм,

Засгийн газрын хувьд IPO гэх юм бол бид нэг 30-аад төрийн өмчийн үйлдвэрийн газрууд дээр нээлттэй ХК болгож, дотоодын бирж дээр хувьцаа арилжаалж, ийм бүтцийн өөрчлөлт хийхээр Улсын Их Хурлаас ийм шийдвэр гаргуулчихсан. Энэ хүрээндээ ажиллаад явж байгаа. Одоогоор Төрийн банк, Хөрөнгийн бирж гэсэн компаниуд амжилттай IPO-гаа гаргаад явж байгаа. Цаашидаа эдгээр компаниуд бол ингээд ойрын хугацаанд зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгийн захын боломжийг харж байгаад боломжит цонх үеэр нь ингээд цуваад цуваад гараад явна. Удахгүй мөн давхар даатгалын компани Сангийн яамны удирдлага дор IPO хийх гэж байгаа. Тийм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нэмж хариулах уу? Баттөмөр гишүүн нэмж асуулт асууя.

**Б.Баттөмөр:** Тэр би сая бонд гэдгийг IPO гээд яачихлаа, уучлаарай, тэрийг тэгж залруулах ёстой. Нийслэл бол бонд гаргаж байгаа бол зүйтэй. Энэ зах зээлийн эдийн засгийн зөв голдирлоороо явж байгаагийн нэг хэлбэр гэж ингэж ойлгож байгаа. Ер нь бол Засгийн газрын түвшинд бол энэ IPO гаргах асуудлыг бас судалгаа шинжилгээ хийж, ингэж гаргах нь бол зүйтэй гэж ингэж үзэж байгаа.

Ер нь бол хүнсний бүтээгдэхүүний инфляцын голлох нь бол хүнсний бүтээгдэхүүн дээр байж байгаа юм. Тэгэхээр энэ инфляцын голлох нь бол мах, гурил гээд гол, гол юм байж байгаа юм л даа. Би жишээ авч ярьж байгаа юм. Махны үнэ өнөөдөр 71 сая малтай 1кг мах бол 26 мянган төгрөг болчихсон байгаа юм. Энийг л ярьж байгаа юм л даа. Тэр урсгал зардал бол байнга хэмнэгдэж байх ёстой шүү. 79 хувь байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хариулт, санал хэлсэн үү. Цогтгэрэл гишүүн. Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

**О.Цогтгэрэл:** Төсвийн тодотгол дээр цалин, тэтгэвэр тэтгэмж нэмэгдэж байгааг мэдээж олон нийт таатай хүлээж авч таарна. Тэгэхээр энэний цаана бас тодорхой тийм эрсдэлүүдийн тоо баримтуудыг харахаар зүйлсүүд харагдаад байгаа юм. Өнгөрсөн хугацаанд 20 хэдэн сая төгрөг тонн нүүрс одоогоор гаргасан нь Хятадын импортлож байгаа коксжих нүүрсний 50-иад хувийг гаргачихсан юм шиг байгаа юм. Үлдэх хугацаа нь манайх тодотгол хийгээд тавиад сая тонныг гаргах юм байна. Хятад 80 сая тонн коксжих нүүрс импортлох юм байна. Тэгэхээр энэ чинь Хятад улс коксжих нүүрс 80 сая тонныг импортлож байгаагийнхаа бараг ганцхан улсаас ч 60, 70 хувийг нь авчихна гэж энэ чинь арай хэтэрхий өөдрөг төсөөлөл биш үү. Дахиад тэр харахаар тэр Австралитай худалдааны тодорхой асуудлуудтай байсныгаа нээгээд, Австралиас илүү их хэмжээний нийлүүлэлт хийгдэх юм шиг байгаа юм. Тэгэхээр наад тоо хэмжээ дээр гарч байгаа, энэ тодотгол дээр тавигдаж байгаа орлого төсөвлөж тооцож байгаа энэ тоо чинь энэний цаана тийм тодорхой тийм эрсдэлүүд харагдаад байгаа юм биш үү? Энэ дээр бас нэг тайлбарууд өгөөч.

Дахиад үнийн асуудал дээр 140 байж, одоо 110-аар ч байна уу тооцож байгаа байх. Яг тэр олон улсын биржийн үнэ, Хятадын цинхандогийн үнэ энэ тэр бол 108 гэсэн тоо яг өнөөдөр харагдаж байна лээ. Та нарын тавьж байгаа төсөвт тооцож байгаа үнээс чинь доошоо орчихсон. Энэ хандлага тренд нь өөрөө сүүлийн 6 сарын хугацаанд сар бүхэн үнэ унаж байгаа. Тэр байтугай бүүр оргил үеэс бол бараг 4 дахин унаж байгаа. Сүүлийн зургаахан сарын хугацаанд. Тэгэхээр орлого тооцож байгаа тоо хэмжээний хувьд ч тэр, үнийн хувьд ч тэр энэ нүүрсний орлогоос тооцож байгаа мөнгө чинь энэний цаана их том эрсдэл харагдаад байгаа юм биш үү. Яг ямар үндэслэлээр ийм тоо хэмжээ, ийм үнийг яг ямар үндэслэлээр тооцож байгаа юм бэ?

2 дугаарт нь үүнийг дагаад 2 их наяд төгрөгөөр нийлүүлэлт нэмэгдэх юм байна зах зээл рүү. Тэгээд үүнийг дагаад үнэ ханишийн уналт, инфляцын асуудлыг яг яаж нөлөөлнө гэж бодож байгаа юм зах зээлд. Тэгээд эцэст нь яг энэтэй холбоотой дахиад энэ бүхэн чинь төсвийн зардал дээр очиж сууна. Дахиад л бид нарын нөгөө төрийн, төсвийн томролт гэдэг, одоо чинь энийг ингээд нэмэгдвэл бараг 40-өөд хувь руугаа очих очиж байгаа байлгүй төсөв. Тэгэхээр энэний цаана нөгөө нэг том төсөв, том данхар төр, олон зүйлүүд чинь нөгөө бүтээмжид суурилагагүй, нэг уул уурхайн үнийн өсөлтөөс авчраад олон нийтдээ тараачихдаг, энэ нь төрөөр дамжаад явдаг. Энэ чинь өөрөө яг энэ зах зээлийн энэ бүтцийн чинь, эдийн засгийн бүтцийг ингээд буруу зүгт залаад байгаа юм биш үү? Тэгээд энэ нэг ийм тодорхой хэмжээний энэ нэг ийм эрсдэлүүд бүхий үзүүлэлтүүд дээр нэг хариулт өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Гишүүнээ энэ 50 сая тонн чинь бүгдээрээ коксожсон нүүрс биш л дээ. Коксожсон нүүрс, эрчим хүчний нүүрс нийлээд шүү. 6 сар дуусахад нэг хэд хоног дутуу байна. 27, 8 орчим сая тонн бараг болчих болов уу, нийлээд шүү. Тэгэхээр эхний хагас жилд ийм байгаа учраас бид энэ темпээ алдахгүй явъя л гэж байгаа юм. Өнгөрсөн жилүүдийн трендийг харах юм бол ер нь сүүлийн хагастаа нэмэгддэг. Ноднин бол бүүр 2 дахин нэмэгдсэн. Энэ жил бол эхнийхээ хагасыг яг бариад ороход л уг нь 50 орчимд бол хүрчих юм байгаа юм. Тэгэх юм бол бидний энэ зорьж байсан төсвийн орлого маань бүрдэх бүрэн боломжтой. Үнийн хувьд бол тантай санал нийлж байна. Бид бол нөлөөлж чадахгүй байна. Энэ биднээс шалтгаалахгүй тогтдог үнэ. Гэхдээ 180 хүрч байсны хувьд бол мэдээж унасан, бас л өдийд унадаг. 7, 8 сараас эргээд өсдөг л, сүүлийн 10 гаруй жилийн ийм тренд байгаа.

Гэсэн хэдий ч одоо уначихсан байхдаа бидний төсөвлөсөн 140 гэдэг энэ жилийн дундаж үнэ дээрээ л байгаа. Унаад, унаад. Цаашид эндээс доош бол бид нар унахгүй гэж ингээж харж байгаа юм. Ийм юм байгаа юм. Тэгээд урсгал зардал бол нэмэгдэнэ. Энэ удаагийн төсвийн тодотголын онцлог бол бид үндсэн тэнцлээ буюу алдагдлаа 2,6 хувь дээрээ барьж орж байгаа. Үндсэн тэнцлийнхээ алдагдлыг бол бид нар нэмээгүй. Орлого, зарлага 2 тэнцээж оруулж байгаа учраас яах вэ мөнгөний нийлүүлэлтэд тэгж хүчтэй бас нөлөөлөхгүй. Гэхдээ энэ бүх мөнгө маань нэг дор бас ингээд шууд нар хийдэл, зах зээл рүү гарахгүй. Шат дараатай үе шаттай гарна. Энд нэг зүйл байгаа юм. Аягүй олон хүн асуугаад байгаа юм. Тэтгэвэр нэмнэ, цалин нэмнэ, нэмнэ л гэдэг. Ингээд нэмэх арга хэмжээ авахаар болохгүй, болохгүй, болохгүй үнэ нэмэгдэнэ, инфляц хөөрөгдлөө л гэдэг. Яах вэ онолоороо тийм юм бол байгаа.

Үүний чинь эсрэг Засгийн газар ч тэр, мөнгөний бодлого ч тэр чиглэсэн арга хэмжээнүүдээ авна. Энэ дээр зүгээр нэг л зүйлийг тодруулж хэлмээр байгаа юм. Сүүлийн 3 жил өрхийн орлого яг иргэдийн түвшинд байнга буурч ирсэн. 22 онд ч буурсан. Эдийн засаг нь өсөөд байдаг, иргэд дээрээ энэ нь буураад байдаг. Одоо бид инфляцын түвшнийг 6 хувь, 8 хувь, мөнгөний бодлогын зорилтот түвшинд хүртэл хүлээнэ гэх юм бол дахиад жил хүлээнэ. Дахиад тэрнээс урт хүлээхийг ч үгүйсгэхгүй. Тэгээд тэр болтол бид нар цалингаа нэмэхгүй, тэтгэврээ нэмэхгүй байх юм бол энэ хүн ам энэ ард иргэд маань тэр болтол тэсэхгүй шүү дээ энэ хугацааг.

Тийм учраас бид энэ төсвийн орлого боломж бүрдэж байгаа эхний цаг мөчид энэ арга хэмжээг авч үүгээрээ цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөөрөө дамжуулж хүн амын бодит орлогыг дэмжиж байгаа ийм л тодотгол юм байгаа юм. Тийм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болсон уу? Доржханд гишүүн, Доржханд гишүүний микрофоныг нээе.

**Т.Доржханд:** Би яг саяын л асуудлыг тодруулаад асуучихмаар байна л даа. Үндсэн хуулийн өөрчлөлт ингээд яриад явж байхад хүмүүс нөгөө тогтолцоо, тооны асуудал гэхээсээ илүү энэ бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт цалин тэтгэвэр ярьсан нь үнэн, үнэн. Тэгээд яалт ч үгүй бас иргэдэд тийм хүлээлт байх нь байх шиг байна. Гэхдээ яг бодит агуулгаараа болохоор манай төсөв чинь бол тэлчихсэн төсөв. 20 орчим их наяд, дахиад 1,8 их наядын нэмэлт орж ирж байна. Тэгээд яах вэ нэмээд байж болно, болно. Гэтэл яг цаашаа яах билээ гэдэг л асуудал байна л даа. Асуудал нь юу байна вэ гээд тэгэхээр бид нар нөгөө чөтгөрийн тойрогт байгаа шүү дээ энэ чинь. Инфляц нь 11,3 хувьтай өндөр инфляцтай байгаа үед бид нар ингээд зах зээл рүү мөнгө нийлүүлээд л байх тохиолдолд бол инфляцын тэр зорилтот түвшин 8 хувь руу чинь орж ирэхгүй шүү дээ. Энэ жил бол байхгүй.

Тэгээд сонгуулийн жил ирэх жил байна, дахиад л бас төсвөө тэлээд л явна. Мөнгөний бодлогын орон зай байхгүй. Тэгээд энийг бол манай энэ 2 сайд бол хоёулаа маш сайн мэдэж байгаа шүү дээ, маш сайн мэдэж байгаа. Хоёулаа Сангийн яам, Монголбанкны хүмүүс тоон дээр бол сайн мэдэж байгаа. Тэгэхээр яах вэ өнөө маргаашдаа болж байна. Дунд хугацаанд яах билээ. Эдийн засгийн сайдаас нэг асуучихмаар байх юм энэ мөнгөний нийлүүлэлт өсөхөөр инфляцаа яг одоо энэ жил, ирэх жилдээ та бүгд яг яаж барих билээ нэг? Үнэхээр буулгаж чадах уу? Эргээд энэ чинь болохоороо төлбөрийн баланс дээрээ эффект үзүүлнэ. Дахиад одоо нэг арай гэж тогтворжиж байгаа доллар дээр чинь дахиад л ингээд цохилт ирнэ шүү дээ. Энэ мөнгө чинь. Тэгээд ирэхээрээ ханшаа ингээд алдчихдаг. Гэтэл бодит байдал дээр ханшаа бид нар алдах л юм бол гаднын хөрөнгө оруулалтыг яаж ч та хичээгээд босгож ирэх боломж байхгүй шүү дээ. Тэгээд

экспорт чинь яг энүүгээрээ байх уу гээд тэгэхээр экспорт чинь өнөөдөр бол таатай нөхцөл бол байх шиг байна.

Яагаад вэ гэхээр Индонез, тэгээд цаашаа Австрали худалдааны дайн гээд Хятад руу экспорт хийхгүй. Бид нар боломжоо бол Оросуудад алдчихсан нь үнэн. Цаашаа энэ орон зай чинь улам л ингээд хумигдаад байгаа тохиолдолд бид нар чинь нүүрснийхээ экспортыг дунд хугацаандаа яг өнөөдрийнх шигээ хийнэ гэдэг төсөөлөл байхгүй шүү дээ. Тэгээд байхгүй тохиолдолд экспортоо сайн хийж чадах уу? Орлого, долларын валютын урсах орж ирэх орлого чинь бол эрсдэлтэй байна. Ханишаа алдаад яваад байх юм бол хөрөнгө оруулалт чинь орж ирэхгүй. Тэгээд гаднын зээл тусламж авъя гээд тэгэх юм бол өрийн тааз чинь ингээд тулчихсан, 3 урсгал байхгүй гээд. Тэгэхээр энэ дунд хугацаандаа яах юм бэ? Латин Америкийн орнууд бол яг ийм л байдлаар цалин тэтгэврээ нэмж явсаар байгаад л тэгээд л дампуурчихсан шүү дээ. Дунд хугацаандаа урт, хугацаандаа. Африкийн орнууд бүгдээрээ л тэгж явсан. Тэгэхээр энэ нөлөөллийг та бүгд яаж харж байгаа юм бэ гэдгийг нэг асуучихмаар байна.

2 дахь нь нөгөө Сангийн сайдаас нэг асуучихмаар байна л даа. Тэтгэврийн асуудал тэтгэврийн зөрүү гээд нөгөө параметрийн тохируулгыг бол ингээд хийгээд байх шиг байна. Тэтгэврийн бас суурь реформ ч гэсэн тэр, Нийгмийн даатгалын багц хууль нь ч гэсэн яг нөгөө суурь өөрчлөлт гэхээсээ илүү дахиад л параметрийн тохируулга яваад байна л даа. Тэгсэн мөртөө 2030 оноос хойш нөгөө тэтгэврийн суурь шинэчлэл рүүгээ орно буюу хагас хуримтлалын тогтолцоо, бүтэн хуримтлалын тогтолцоо хойшоо орно гээд шидчихсэн. Тэгээд цаашаага нөгөө мөнгө яагаад орохгүй байна вэ гэхээр мөнгө байхгүй, эх үүсвэр байхгүй. Тийм болохоор хойшоо шийдээд байдаг. Тэгээд нөгөө гал унтраасан байдлаар бид нар ингээд яваад байхаар цогц реформ чинь ингээд хойшлогдоод байна шүү дээ. Тэгээд л 4 жил болгон сонгууль болно,

асуудал үүснэ. Эдийн засгийн цикл нь нөгөө уул уурхайгаас хамааралтай болохоороо 3, 4 жилийн хугацаатай савладаг. Тэгээд тэрэнд тохируулга хийсээр байгаад бид нар чинь ингээд том реформуудаа ч хийж чадахгүй, алдах гээд байна шүү дээ. Тэгээд энэ дээр.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Эдийн засаг хөгжлийн сайд Хүрэлбаатар сайд хариулъя эхлээд.

**Ч.Хүрэлбаатар:** Нэгэнт зардал, төсвийн зардал нэмэгдэж байгаа юм чинь инфляцад нөлөөлөх үү гэж нөлөөлнө. Тэгэхээр бид нар энэ инфляц дээрээ нөлөөллийг нь бууруулахын тулд мөнгөний бодлоготойгоо бас мөнгөний бодлогоо бас өөрчлөх ч юм уу ийм шаардлага бол байгаа. Төсвийн зардал 1,8 тэрбум их наяд төгрөгөөр нэмэгдчихсэн байхад үнэд нөлөөлөхгүй гэж худлаа ярьж болохгүй шүү дээ. Эдийн засагч хүмүүс суучаад. Тийм учраас нөлөөлнө. Тэгэхээр мөнгөний бодлогоо бид нар бол нэлээд эргэж харж авч үзэх 1 дүгээрт шаардлага бий болж магадгүй.

2 дугаарт нь бараа, бүтээгдэхүүнүүдийн өрсөлдөөнийг нэлээн сайн нэмэгдүүлэх ийм арга хэмжээг бол авах шаардлагатай байгаа юм. Жишээлбэл мах борлууллаа гэж бодоход мах борлуулахад нөлөөлж байгаа юу гэдэг юм малчны хотноос гараад дэлгүүрийн лангуун дээр очих хугацаанд төрийн зүгээс учруулдаг бүх төрлийн саад бэрхшээлүүдийг бүгдийг нь алга болгох хэрэгтэй. Ингэж чадвал бараа бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлтүүд нэмэгдэнэ шүү дээ. Өөрөөр хэлбэл энэ үед өрсөлдөөн нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг бол Засгийн газар бол авч хэрэгжүүлэх учиртай. Тэгээд үүнтэй холбоотой зүйлүүдийг маргаашийн Засгийн газрын хуралдаан дээр ярихаар төлөвлөж байна.

Дараагийн зүйл бол манай экспортыг бид нар цаашаа л нэлээн сайн

нэмэх шаардлагатай байгаа. Тэгээд нөөц бололцоо бий юу гэвэл бий. Монгол Улс бас том зах зээлтэй холбоотой. Тэгээд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дажгүй байна. Бас уул уурхайн бүтээгдэхүүнээ Монголчууд үнэ хүргээд зардаг болчихлоо. Хэдийгээр эсэргүүцэж байгаа хүмүүс байгаа ч гэсэн. Хэдийгээр нүүрсний хэмжээ унаж байна гээд зарим нэг нь баярлаад байгаа ч гэсэн. Борлуулж байгаа бараа бүтээгдэхүүнүүдээсээ олох орлогоо бид нар нэмж байгаа. Нөгөө биржээр зардаг бүтээгдэхүүнүүддээ бид нар төмөр нэмж байгаа. Төмрийн хүдрээ. Зах зээлээс хэд дахин доор зарж байгаа тохиолдлууд байгаа шүү дээ манайд. Энэ юмнуудаа л гүйцэд авдаг болчихоод бид нар юу гэдэг юм энд тэндээс мөнгө хайгаад, гүйгээд байхгүйгээр яваад ирчих ийм бүрэн боломж бол байгаа.

Тэгэхээр ер нь жсоохон улс төрийн хувьд ч гэсэн нэлээд тийм шахуу шаардлага тавигдаж байна. Эдийн засгийн хувьд ч гэсэн нэг их бодлогууд улам сайн болох, улам энэ өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, улам нийлүүлэлтийг нэмэх гэсэн ийм бодлогод явж явагдаад явуулах явуулна. Тэгэхээр энэ бодлогуудаа л бид нар сайн хийх хэрэгтэй. Янз бүрийн төрийн хиймэл хүнд суртлууд, хиймэл саад бэрхшээлүүд эсвэл хил хааж байгаад хөгжинө гэдэг тийм гэнэн хонгор бодол эсвэл нарийн төмөр зам барьчихвал Хятадын танк ороод ирнэ гэдэг ийм нэг хэт явцуу үзэл бодол иймэрхүү тэнэглэлүүдээсээ салчихад бол эдийн засаг Монгол Улсын эдийн засаг хурдацтай хөгжих боломжтой. Янз бүрийн асуудлуудыг шийдэх боломжуудаа гаргачихна гэсэн ийм л бодолтой байгаа. Дунд хугацаанд ч гэсэн энэ бодлогоо бид нар тууштай авч үргэлжлүүлэх хэрэгтэй. Харин тийм тэнэг, тэнэг юм хийгээд байдаг хүмүүсийг дахиж амилуулахгүй байх дээр л улс төр дээр нь бол бид нар хэдүүлээ анхаарах ёстой гэж л бодож байна. Тэгвэл эдийн засгийн юм бол хэвийн горимд ороод, ном журмаараа явахад бол Монгол жижиг улс, жижиг эдийн засагт энэ олон асуудлууд нэг их хүндрэл

үүсэхгүйгээр явчих боломжтой гэж бодож байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Тантай санал нийлж байна, нийлж байна. Нийгмийн даатгалын багц хууль өргөн баригдчихсан байх? Өргөн баригдчихсан одоо ингээд хэлэлцээд явна. Тэрэн дотор байгаа яг реформ хийх суурь өөрчлөлтүүдийн ер нь 50 хувь нь энэ удаагийн тодотголоор ер нь ингээд хийгдчихэж байгаа юм. Таны яг ярьж байгаа тэр хугацаа 30 оноос хойш гээд ер нь яах вэ төсвөөс аль болох хамаарал нь багасгах л шүү дээ гол суурь концепц маань. Тэрэн дээр мэдээж ачаалал ирнэ. Гэхдээ энэ өөрчлөлтийг энэ удаа хийснээр энэ урт хугацааны энэ өөрчлөлт нь бас тэр хэмжээгээр хугацаа нь наашилж байна л гэсэн үг. Энэ суурь өөрчлөлтүүдийг хийхгүйгээр бид нар том реформ маань өөрөө явахгүй.

Өнөөдөр төсөв дээр мэдээж дарамт нь нэмэгдэж байгаа хэдий ч том утгаараа бол бид нар реформоо бүтэн үр дүнд хүргэх урт хугацаа нь харин тэр хэмжээгээр наашилна л гэж ойлгох хэрэгтэй. Тэгээд ийм л зорилготой ийм агуулгаар бид энэ удаа бол ингээд зориглоод хийчхэж байгаа юм. Том эдийн засгийн нөлөөллийн хувьд бол 1 их наяд 896 тэрбум гэдэг маань 70 хувь нь гэх юм бол 400-гаад сая долларын төлбөрийн тэнцлийн сөрөг дарамт ирнэ. Бид нар үүнийг давсан экспортоо л нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа. Тэгж байж үнэ ханшаа бид нар нөөцөө хамгаалах ийм зорилготойгоор л Засгийн газар маань ажиллана. Сая детальчлан хийж байгаа ажлуудынхаа талаар Хүрэлбаатар сайд дурдчихлаа. Тэр нь том зорилго дээрээ бол ерөөсөө энэ. Тэгэхээр Их хурал ч тэр, Засгийн газар ч тэр нэг шугам дээр байна гэдэгт итгэлтэй байна би баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Доржханд гишүүн тодруулъя.

**Т.Доржханд:** Нэг ойлголттой л байгаа юм байна. Хүрэлбаатар сайд тэр нэг холбогддоггүй зам маань хэзээ ашиглалтад орох юм бэ? 2, 3 жилийн дараа бол тэр төмөр замын үр өгөөж байхгүй болчих гээд байна шүү дээ. Тэгээд энэ моментоо бид нар алдах гээд байна шүү дээ. Австралитай, Хятадын энэ харилцааны энэ боломжийг бид нар дахиад алдмааргүй байгаа байхгүй юу 1. 2 дугаарт энэ долларын ханшаа баримаар байгаа юм. Тэгэхгүй бол гаднын хөрөнгө оруулалт байхгүй. Бид нар зөвхөн экспорт, экспорт гэж явж байгаад одоо ингээд төгрөг нийлүүлээд ханшаа алдах юм бол гаднын хөрөнгө оруулалт дахиад байхгүй шүү дээ. Тэгээд тийм болохоор 1 дүгээрт экспортоо нэмэгдүүлэх, 2 дугаарт ханшаа алдахгүй байх, тэгээд 3 дугаарт бол тэр бага эх үүсвэртэй хөрөнгө оруулж ирэх гээд яг ийм дарааллаар явмаар байх юм. Тэгээд энэ дээр та бүгд маань Засгийн газар дээр ярьсан зүйл байна уу, үгүй юу? Яг өнөөдрийн тодотгол чинь бол энэ хани дээр чинь цохилт ирээд, энэ бодлогын арга хэрэгслийг чинь тэр мөнгөний бодлогын орон зайг чинь хумьчхаад байна шүү дээ. Тэгээд мөнгөний бодлого чангарахаас өөр аргагүй шүү дээ. Тэгэхээр намраас чинь бизнес чинь яах билээ, зээлийн хүү чинь яах билээ?

**Ж.Бат-Эрдэнэ:** Хүрэлбаатар сайд нэмж хариулах уу.

**Ч.Хүрэлбаатар:** Тийм. Одоо энэ хил рүү явсан бараг 500-гаад километрийн төмөр замуудыг бид нар цаад талын холбох ажлыг бол хийх ёстой. Гашуун сухайтын тэр төмөр зам бол цаад талаасаа бол Чайна Энержигийн нь эзэмшдэг төмөр зам, Монголоос бол Монголын төмөр замын зам. Тэгэхээр энэ 2 компани хоорондоо ярилцах ёстой болов уу. Тэгээд энийгээ хурдан холбох чиглэлийн ажлууд нэлээд яригдаад явж байгаа. Холбох цэг эд нараа тохирчихсон, одоо хэрхэн яаж хийх вэ гэдэг юм яригдаж байгаа.

Нөгөөх нь бол Ханги байгаа. Хангийг бол тэр холбогдох газар нь бол бас харьцангуй нөхцөл байдалд нь бол амар. Тэгэхээр энийг бол Засгийн газар бол БНХАУ-тай бол бүх талаараа л энэ ойрын хугацаанд холбочих чиглэлийн асуудлуудыг яриад л, хэлцлүүд бол.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ төмөр замтай холбоотой асуудал бас ярихгүй л бол болохгүй л болчхоод байгаа шүү дээ. Өнөрболор гишүүн. Өнөрболор гишүүний микрофоныг өгье.

**Д.Өнөрболор:** Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр бол энэ төсвийн тодотгол орж ирж байна, цалин тэтгэврийн хувьд бол нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байсан уу гээд тэгэхээр үнэхээр шаардлагатай байсан. Ялангуяа энэ орон нутгийн анхан шатанд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж өнөөдөр наад захын амьжиргаанд тийм ээ хүрэлцэхгүй байх ийм ноцтой хэмжээнд байсан. Тийм учраас бол тэтгэвэр тэтгэмжийг бол, энэ цалин хөлсийг бол нэмэгдүүлэх шаардлага байсан гэж бол үзэж байгаа юм.

Нөгөө талаар энэ төсөв эдийн засагт бодит дэмжлэг үзүүлдэг байх ёстой. Энэ урсгалын зардлын өсөлтийг эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нь бууруулах, өсөлтийг хэвээр хадгалах, инфляцын энэ үнийн өсөлтийг бууруулахад ер нь яг ямар арга хэмжээ авч байгаа вэ? Бид нар бол үндсэндээ бол энэ бодлогын хүүг нэмэгдүүлнэ гэсэн нэг л механизмтай л байгаад байгаа. Ийм л асуудал байгаад байна уу? Тэгээд энэний чинь үр дагаврууд нь бол бас маш сөрөг байгаад байгаа. Тэгэхээр өөр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр байгаа вэ?

Энэ үнийн өсөлт инфляц бол бодитоор өнөөдөр орисоор байгаа. Цаашид ч ер нь өсөх эрсдэл бол байгаа. Тэгээд өмнө нь энэ эдийн засгийг 5 хувиар өснө гэж тооцож байхад инфляцыг 8 хувь гэж бол баталж байсан тийм ээ. Гэтэл

өсөлтийг 7,9 хувиа гэж хүрчхээд байхад инфляцыг 10 хувь болгоод өсгөөд оруулаад ирж байна л даа. Тэгэхээр логикийн хувьд бол энэ эдийн засаг өөрөө өсөхөд бусад үзүүлэлтүүд нь бол дагаад сайжирч байх ёстой шүү дээ. Тухайлбал инфляц тийм ээ, энэ бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт саарах ёстой, иргэдэд ирэх энэ санхүүгийн дарамт нь буурах ёстой, ард иргэдийн энэ ажлын байр, орлого нэмэгдэх ёстой гээд. Тэгээд ингээд энэ, энэ болгон чинь яг ингээд хүмүүсийн амьдрал дээр ингээд мэдрэгдэхгүй байгаа болохоор чинь хүмүүс ингээд аягүй шүүмжлэлтэй хатуу хандаад байгаа байхгүй. Энэ ард иргэд, судлаачид ч гэсэн бас энэ яг энэ эдийн засгийн өсөлт чинь өөрөө өсөлт мөн үү гэдэг дээр бол маш хатуу шүүмжлэлтэй хандаж байна шүү дээ.

Дараагийн нэг асуудал нь бол энэ бусад гишүүд ч гэсэн бас нэлээдгүй хэлж байна л даа. Ер нь энэ экспортоо 50 сая тонн гэж бол хэт өөдрөг та нар төлөвлөж байгаа юм биш үү гэж. Тэгээд би хэн Хүрэлбаатар сайдаас бол бас асуумаар байгаад байгаа юм л даа. Энэ биет байдлаараа ер нь сүүлийн саруудад бол ингээд буурч байгаа. Тэр нь бол энэ сүүлийн жилүүдийн статистикаар аваад үзэх юм бол нүүрсний экспорт буурдаг ийм жишигтэй гэж бол тайлбарлаад байгаа юм л даа. Гэтэл геополитикийн тодорхойгүй нөхцөл байдал үргэлжилсэн хэвээрээ байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2 хувиас бага байх магадлалтай байна. Тэгээд саяхан гарсан энэ Хятад улсын гадаад худалдааны үзүүлэлтээр бол өмнөх сараас экспорт нь 7,5 хувиар бол буурсан байгаа юм. Импорт нь бол 4,5 хувиар буурсан ийм үзүүлэлттэй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ гадаад худалдааны үзүүлэлтээр сүүлийн 2 сар бол дараалан буурч байгаа. Сүүлийн сар гаруй хугацаанд бол нүүрс коксын үнэ ч гэсэн бас давхар буурч байгаа ийм нөхцөл байдалтай байгаа юм. Тэгээд энэ 50 сая гэсэн нүүрс экспортлох төлөвлөлт маань бол яг бодит биеллээ олж чадах уу, биелэх үү гэдэг бас ийм асуулт байна.

Тэгээд энэ хэрэв биеллээ олж чадаагүй байгаа тохиолдолд энэ орлогын эх үүсвэрүүдийг дагаад бол маш их олон салбаруудын зорилтууд төлөвлөлтүүд бол ингээд дагаад давхар төлөвлөгдсөн байж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ урсгал зардлын энэ өсөлт алдагдал болж төсөв дээр бол дарамт болж ирэх үү дээ. Энэ биелбэл сайн байна. Биелэхгүй байгаа тохиолдлын эрсдэлийн менежментийг та нар юу гэж авч үзэж байгаа юм бэ? Энэ дээр нэг нэн ялангуяа энэ хариуцлагын тогтолцоо ярьж байгаа тохиолдолд магадгүй биелэхгүй байх тохиолдолд хариуцах асуудлыг бол яг яаж харж байгаа юм бэ? Хэн хариуцах юм бэ? Ер нь юу гэдэг юм тооцоо судалгаа дээр үндэслээд хэн баталгаа өгөөд байгаа юм бэ? Тооцоо судалгаа дээр үндэслэсэн бас энэ хариу.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ? Сангийн яам, Сангийн сайд Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Эрсдэлгүй зүйл, Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Эрсдэлгүй зүйл гэж юу байх вэ? Ялангуяа биднээс шалтгаалдаггүй гадаад зах зээлийн нөхцөлөөс шалтгаалдаг зүйл дээр бол эрсдэл бол өмнө нь ч байсан, цаашидаа ч байна. Бид өөрсдөөсөө шалтгаалах зүйл дээрээ л их сайн ажиллах хэрэгтэй байгаа юм. Ер нь бол яах вэ Төв банкны бодлогын хүү бол аливаа инфляцын эрэлт талаас нь нөлөөлөл их үзүүлдэг. Засгийн газар бол нийлүүлэлт талаас нь л ийм шок үүсгэхгүй байх энэ тал дээрээ ажиллаад явж байгаа. Засгийн газрын талаас хүлээдэг үүрэг бол харьцангуй биелэлт сайтай явж байгаа. Өөрөөр хэлбэл хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадвар, бараа материалын хомсдол бол үндсэндээ арилаад байна. Зүгээр гадаад зах зээлээс орж ирж байгаа инфляц шингээсэн, гадна талдаа үнэтэй байгаа зүйлүүдийг бол бид тэр бүр шууд нөлөөлж чадахгүй ингэж явж ирж байгаа.

Нүүрсний хувьд бол энэ жил бид нар эхний хагас жилд гаргасныгаа л сүүлийн хагас жилд гаргая гэж байгаа

юм. Тэгэхээр энэ бол маш боломжтой ийм тоо байгаа. Хятадын зах зээл бол коксожсон нүүрс, эрчим хүчний нүүрс нийлээд бол 400-аас 500 сая тонн. Бид нарын хувьд бол нийлээд 50 сая тонныг гаргана гэж байгаа нь бол Хятадын зах зээл бусад өрсөлдөгч нарыгаа бүгдийг нь оруулаад, оруулаад бид нарт цаана нь хангалттай зах зээл байгаа гэдгийг Хятадын талаас бол байнга хэлж байгаа. Авчирч чадсан хэмжээгээр чинь бид нар худалдаж авна гэдгийг сая өнгөрсөн Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр ч гэсэн Хятадын дээд хэмжээндээ ингэж мэдэгдсэн байгаа. Тэгэхээр энэ асуудал бол үнийн хувьд бол биднээс шалтгаалахгүй. Харин гаргах биет хэмжээний хувьд бол шууд биднээс шалтгаалах ийм л асуудал байгаа гэж хэлмээр байна. Тийм учраас энэ бас болохгүй амжихгүй ийм зорилт биш гэж ингэж бодож байна.

Хариуцлагын асуудлыг тэгээд Их Хурал дээр шийдчихнэ биз дээ. Одоо болохгүй бол. Бусад мэдээж эрсдэл гэдэг нь механик эрсдэлүүд, хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадвар болон өөр юу байдаг юм, энэ бүх зүйл бол мэдээж Засгийн газар талаас гадаад харилцааны асуудлууд ч байна, техник логистикийн асуудлууд ч байна. Тийм. Тэгээд энэ ямар саад гарах юм одоо шууд хэлж мэдэхгүй байна. Гэхдээ Засгийн газар бол бүх талаар л эрсдэлгүй байлгах тал дээр ажиллаж байна даа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тодруулах уу? Өнөрболор гишүүн тодруулъя.

**Д.Өнөрболор:** Энэ үнийн өсөлт инфляцын энэ өсөлт дээр авч хэрэгжүүлэх арга механизмууд чинь яг юу юм бэ? Ер нь бол энэ бодлогын хүү нэмэгдүүлнэ л гэсэн асуудал байгаад байгаа юм уу? Эсвэл бусад өөр улс орнууд бол бас энэ үйлдвэрлэлийг юу яах, нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийнхээ юу гэдэг юм нөгөө юу, нөгөө үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх тийм ээ, мөн юу гэдэг юм дотооддоо тэр хөрөнгө оруулалтыг татахаас гадна илүү ахиад тийм,

хөрөнгө оруулалтыг татахаас гадна өөр ахиад дотоодынхоо энэ ААН-үүд, баялаг бүтээгчид энэ бизнес эрхлэгчдийнхээ энэ засаглалыг сайжруулах, мөн юу гэдэг юм эрсдэл даах энэ чадавхуудыг нь сайжруулах гээд маш их олон энэ арга хэмжээнүүдийг бол дотооддоо ингээд авч хэрэгжүүлж байна шүү дээ. Ер нь манай яг Засгийн газар дээр бол авч хэрэгжүүлж байгаа яг ямар арга хэмжээнүүд байгаад байгаа вэ?

**Ж.Бат-Эрдэнэ:** Хүрэлбаатар сайд хариулъя. Хүрэлбаатар сайдын микрофоныг өгье, Эдийн засаг хөгжлийн сайд Хүрэлбаатар сайдын микрофоныг өгье. Наад юу чинь ажиллахгүй л байна даа. Хүрэлбаатар сайдын микрофон.

**Ч.Хүрэлбаатар:** Өнөрболор гишүүнээ ер нь бол инфляцдаа бол авч хэрэгжүүлж байгаа энэ юу бол нэг номерт нь бол мөнгөний бодлого. Мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцыг барихаас өөр аргагүй. Үүнээс өмнө бол бид нар хараад Монгол Улсын дээр ч гэсэн туршаад үзчихсэн шүү дээ. Инфляцын үед инфляц Монгол Улсын өөрийн гэсэн онцлогтой, мөнгөний бодлогоор хийхгүй өөрөөр хийнэ гээд бүтэлгүйтсэн. Дэлхийн зарим улс орнууд ч гэсэн мөнгөний бодлогоос бус өөр арга хэмжээгээр хийх гэж оролдсон бас бүтэлгүйтсэн. Тэгээд хаана сайгүй л мөнгөний бодлого руу орж байгаа. Инфляц явбал мөнгөний бодлогын арга хэмжээнүүдийг авах, авч хэрэгжүүлэхээс өөр аргагүй. Энэ дээр бол өөр сонголт байхгүй.

2 дугаарт нь бол бид нар энэ бас бусад орнууд зарим нэг орнуудын авч хэрэгжүүлж байгаа энэ яг ийм үед өрсөлдөөнийг нэмэх, нийлүүлэлтийг нэмэх, нийлүүлэлтийг нэмэхэд бага.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Ундрам гишүүн асуултаа асууя.

**Ч.Ундрам:** Төсвийн тодотгол орж ирж байна. Тэгээд энэ нь бол нэг талаас



нийгмийн хэрэгцээ шаардлага байсан учраас орж ирж байгаа. Нөгөө талаас бас өнгөрсөн хугацаанд энэ ковидтой 2 жил, олон улсын геополитикийн нөхцөл байдлын дараа энэ үеэр ч гэсэн Улсын Их Хурал, Засгийн газар маш сайн менежменттэй ажилласны үндсэн дээр энэ төсвийн тодотголыг хийх боломж нь бүрдээд, өнөөдөр ингээж орж ирж байна гэж харж байгаа.

Хэд хэдэн асуулт байна. 1 дүгээрт бид нар төр цомхон байх ёстой, өндөр бүтээмжтэй, тэгээд тийм цомхон төр байх ёстой гээд өнгөрсөн хугацаанд энэ Цахим хөгжлийн яам байгуулаад ИМонголиа гэдэг төсөл хэрэгжүүлээд, нэлээн цахимжуулаад ингээд явж байна. Төрийн өмчит зарим компаниудыг хувьчилъя гээд эхнээс нь хувьчлаад, зарим нэг үйлчилгээг нь аутсорс хийгээд ингээд явж байна л даа. Гэтэл энэ төрийн албан хаагчдын тоо 2009 онд 148 мянга байсан бол, 21 онд 225 мянга болсон байна, 52 хувиар нэмэгдсэн байна. Гэтэл Монгол Улсын хүн ам энэ хугацаанд 52 хувиар бол нэмэгдээгүй шүү дээ. Тэгээд энэ тоонд ТӨК-ийн компанид ажилладаг 75500 хүн ороогүйгээр шүү. Ороогүйгээр ийм олон хүн ингээд ажиллаад явж байна.

Энэ хуулийн Төсвийн тухай хуулийг дагалдаж байгаа хуулийн төсөлд бол Төрийн албаны тухай хуульд 2025 он гэхэд төрийн албан хаагчийн нийт ажиллах хүчний хүчинд эзлэх хувийг 15 хувиас хэтрэхгүй байна гээд оруулж ирсэн байна л даа. Тэгээд энэ 225 мянга чинь одоо бол нийт ажиллах хүчний 16,9 хувь юм бол, 15 хувь гэдэг чинь 200 мянган хүн байгаа байхгүй юу. Тэгэхээр 25 мянгаар бууруулна гэж орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ бол хангалтгүй тоо л надад санагдаад байна л даа. Нэг талаас яг ямар байдлаар ямар албан хаагчдын орон тоог цөөлж энэ 25 мянган хувь хүнийг багасгах юм бэ? Орон тоог гэдэг нэг асуулт байна. Нөгөө талаас энэнээс өөр дээшээ тийм хасах цомхотгох боломж байхгүй юм уу гэсэн ийм асуулт гарч ирж байгаа юм.

2 дугаар асуулт нь энэ хуулийн танилцуулга хэсэгт бид нар энэ төрийн албыг бүтээмжид суурилж цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна гээд л оруулсан байна. Энэ бол бүгд санал нийлж байгаа байх. Гэхдээ яг яаж, хэзээ энэ бүтээмжид суурилсан цалин хөлсний тогтолцоо чинь орж ирэх юм бэ? Энийг өчнөөн жил яриад, 3 жил яриад өнөөдрийг хүрчихсэн байна. Тэгэхээр энэ яаж орж ирэх юм бэ гэдэг асуулт бас байна.

3 дугаарт хүүхдийн мөнгийг хүсэлт гаргасан хүн болгонд нөхөн олгох, цаашид бас ингээд олгохоор болж байгаа нь маш сайн хэрэг гэж бодож байна. Тэгээд хүүхдийн мөнгийг энэ тогтоолын төсөл дээр хүүхдийн мөнгөн тэтгэмж гээд яг нөгөө халамж тусламж гэдэг тэр бүлэгт нь хэвээр нь үлдээгээд оруулаад ирсэн байна л даа. Хэрвээ энийг хүн болгонд өгөх гэж байгаа бол энийг халамж гэдгээс хасах ёстой гэж би бодож байна. Өөр ангилалд оруулах ёстой. Тэгэхгүй бол өнөөдөр энэ асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сайд нар ярихдаа Монгол Улсын бараг л бүх хүн 9 хувиас бусад бүх хүн ам нь халамж авдаг юм шиг тийм статистик тоо зарим газруудад яригдаад байна л даа. Тэгэхээр энэ тэтгэмж гэдэг нэрийг нь солиод өөр ангилалд нь оруулах ёстой юм биш үү гэсэн ийм асуулт байна.

4-д нь энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал байна. Тэрийг минут дуусаж байгаа учраас тодруулахаар асуучихъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жавхлан сайд хариулах уу? Хаанаас, Хөдөлмөрийн Нийгмийн хамгааллын яамнаас хэн хариулах вэ? 2 Номерын микрофон дээр, ажлын хэсгийн микрофон 2 номерын микрофон дээр. Нэр, албан тушаалаа танилцуулна шүү.

**Б.Алимаа:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Алимаа. Ундрал,

Ундрaм гишүүний асуултад хариулъя. Төрийн албан хаагчдын тоо бол харьцангуй өсөж байгаа. Засгийн газраас өргөн барьсан төсөв дагалдуулан өргөн барьсан хууль дотор Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулаад ажиллах хүчний 15 хувиар төрийн албан хаагчдын тоог цөөрүүлэх ийм бодлого баримталъя гэсэн ийм чиглэл байгаа.

Гэхдээ энэ бол 25 оноос хэрэгжихээр, 26 оноос эхлэн хэрэгжихээр төлөвлөж байгаа. Үе шаттайгаар бууруулах тодорхой арга хэмжээнүүдийг ЗГХЭГ-аас бас санаачилж байгаа. Тухайлбал тодорхой салбарууд дээр ажлын байрны шинжилгээ, чиг үүргийн шинжилгээнүүдийг салбар бүрээр ЗГХЭГ-ын хяналт хариуцсан газраас холбогдох байгууллагатай хамтраад хийж байгаа. Энэ чиглэлээр чиг үүргийн шинжилгээнүүд хийгдээд, ажлын байрны давхцал, чиг үүргийн давхцал юу байх нь вэ гэдэг энэ талаасаа нэгдсэн байдлаар бол дүгнэлт гарна. Тэгээд энэ дээр үндэслээд төрийн албан хаагчдын ангилал ангиллын хувьд хэрхэн яаж орон тоог бууруулах вэ гэдэг бодлого бол нэгдсэн байдлаар ЗГХЭГ дээр гарахаар төлөвлөөд ажиллаж байна.

Бүтээмжид суурилсан цалин хөлсний тогтолцооны хувьд бол Засгийн газар дээр бас үе шаттайгаар хэрэгжүүлээд эхэлж байгаа Ундрaм гишүүнээ. Өнгөрсөн хугацаанд боловсролын салбар, эрүүл мэндийн салбар бол энэ гүйцэтгэлийн санхүүжилт үр дүнд чиглэсэн энэ цалингийн систем рүү бол бас харьцангуй шилжиж эхэлж байгаа. Тийм бүрэн шилжсэн. Одоо зарим ялангуяа энэ төрийн захиргааны албан хаагчдаасаа бусад соёлын гээд энэ салбарууд байж байгаа. Энэ хүмүүсийн гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой, төрийн захиргааны албан хаагчдын хувьд бол бас энэ гүйцэтгэлийг үнэлэх энэ шалгуур үзүүлэлтүүдийг гаргахаар бас Хэрэг эрхлэх дээр ажлын хэсэг гаргаад Амарбаясгалан сайд ахлаад ажиллаж байна.

Соёлын салбар бас энэ гүйцэтгэл рүү шилжих алхмууд бол энэ оноос эхлээд хэрэгжээд явж байна. Тийм учраас ер нь бол энэ бүтээмжид суурилсан гүйцэтгэл үр дүнд чиглэсэн цалин хөлсний системийг нэлээн боловсронгуй болох ёстой. Дээрээс нь бүтээмжид гүйцэтгэлд чиглэсэн энэ цалин хөлснийхөө нэмэгдлийн хувь хэмжээг тодорхой хэмжээгээр нэмэх, тогтмол энэ нэмэгдлүүдийг бас харьцангуй хязгаарлах бас ийм шаардлага байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** 2 номерын микрофон, ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

**А.Хишигбаяр:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хишигбаяр. Ундрaм гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн мөнгийг 2022 онд бол Ирээдүй өв сангийн тухай хуулийн дагуу явж байсан. 91 хувьд олгохтой холбоотой 23 оны төсвийн хуулийг дагуулж бол нийгмийн халамжийн хөтөлбөр болгож бол оруулж ирсэн байгаа. Ингээд энэ хүрээнд бол бид нар тодотголоор бол хүүхдийн мөнгийг бүх хүүхэд, хүсэлт гаргасан бүх хүүхдэд олгож байгаа болохоор бол ерөнхийдөө бол цаашидаа бол нийгмийн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Нийгмийн халамжийн багц хуульдаа бас өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа. Энэ дээрээ бол бас халамжийн хөтөлбөр, хүн амын өсөлтийг дэмжих хөтөлбөр гэсэн 2 хуулиар бол зохицуулалт хийж байгаа. Энэ дээр бол хүн амын өсөлтийг дэмжих энэ хууль руугаа бол хүүхдийн мөнгөө оруулаад явна гэсэн ийм хуулийн төслөө боловсруулаад ажиллаж байгаа. Тэгээд энэ хуулийн хүрээндээ бол бид нар шинэчлээд явна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ундрaм гишүүн тодруулъя Ундрaм гишүүний микрофоныг өгье.

**Ч.Ундрaм:** Энэ төрийн албан хаагчийн тоог цөөлөхдөө мэдээж ажлын

байрны шинжилгээ хийх нь нэг талаас зөв. Нөгөө талаас бас зарим нэг салбаруудад тогтолцооны реформ хийх шаардлагатай гэж би бодож байгаа. Мэдээж салбар, салбар дээр өөр байх. Тэгэхээр та бүхэн ингэж ажиллахдаа зөвхөн ингээд нэгэнт үүсчихсэн байгаа тогтолцоо дээр, ажиллаж байгаа ажлын байрны шинжилгээнээс гадна нийт тогтолцоог нь бид нар яаж илүү бүтээмжтэй болгох юм бэ гэдгийг бас харгалзах ёстой байх гэж хэлмээр байна.

Энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албанд ажиллах боломжийг нэмэгдүүлэхийн тулд шаардлагуудыг нь нэлээн хөнгөвчилсөн ийм заалтууд орж ирж байна л даа. Тэгэхдээ яг энэ заалтыг би бол дэмжиж байгаа хэдий ч Төсвийн тухай хуулийг дагаж ийм зүйл орж ирэх ёстой юм уу, үгүй юү би бол сайн хэлж мэдэхгүй байна. Логикийн хувьд бол ингэх ёсгүй юм шиг санагдаж байгаа. Энэ дээрээс гадна энэ сумдад бас төрийн албанд ажиллах хүн ерөөсөө олдохгүй байна. Шаардлага, шалгуурыг нь давдаг хүн ерөөсөө гарч ирэхгүй байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саяынхтай холбоотой хариулт хэн хэлэх вэ? Хэн хариулах вэ? Сангийн сайд Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Ундрам гишүүний асуултад хариулъя. Үүрэг өгөх шиг боллоо. Бид нар тэгээд дараа дараагийн төсвүүд дээрээ боломжоороо үе шаттай суулгаад л бодлогуудаа үргэлжлүүлээд явна. Тийм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энд нэг сая гишүүд маань бүгд л хэллээ. Энэ ер нь зах зээл дээр бол 1,9 их наяд төгрөг гарч ирж байна шүү дээ. Тэгээд энэтэй холбоотойгоор инфляц нэмэгдэх, мөнгөний тэлэлттэй уялдаад инфляц нэмэгдэх асуудлууд, тэгээд үнийн өсөлт гарах ийм болзошгүй ийм асуудал гарна. Тэгээд энэтэй холбогдуулаад ер нь энэ төсвийн төслөө дагасан юуны Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж орж ирэх шаардлагатай байх. Сангийн

сайд, тэгээд Эдийн засгийн хөгжлийн сайд бас энэ дээр анхаараад, энэ хуулийн төсөлтэйгөө уялдуулаад Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж орж ирж, ер нь бүхий л гишүүд хэлж байна шүү дээ. Тэгэхээр тодорхой инфляцыг тогтворжуулах, инфляцыг барих, тэгээд үнийн өсөлт нь нэмэгдэхгүй байх тодорхой арга хэмжээ тусгасан ийм нэг төсөл оруулж ир гэсэн нэг ийм санал байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төсвийн тодотголын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Одонтуяа гишүүн нэг санал оруулж ирсэн юм байна. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй нэг санал орж ирсэн байна. 1.Төслийн 1 дүгээр хавсралтын 9.1.112.Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг, Улаанбаатар хот, Баянгол гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулахгүйгээр төслийн нэрийг төв замуудын гэрлэн чимэглэл, Улаанбаатар, Баянгол гэж өөрчлөх гэж байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа гэсэн байна. Нэр өөрчлөх юм байна. Баянголд гэж байна. Нэр өөрчлөхөөр орж ирж байгаа юм байна. Санал хураалт. Санал 7,7 хувиар дэмжигдсэнгүй. Ингээд санал хураалт явж дууслаа. Төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцүүлэг хийсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулъя. Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

13.31 цаг

**Гурав. “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” /“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай”**

**Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт/ Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Дараагийн асуудал. Одоо гялалзана. Хэлэлцэх асуудал, гишүүд байж байгаарай. 3 дахь асуудал руу орёе. Тогтоолын төсөл хавсралтыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулна. Хүрэлбаатар сайдын микрофоныг нээе.

**Ч.Хүрэлбаатар:** Эдийн засгийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг, тус тогтоолын 2 дугаар хавсралтаар Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталсан. Коронавируст халдварт цар тахлын улмаас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор тус хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт удааширах, санхүүжилт саатах зэрэг хүндрэлүүд үүссэн тул шинэчлэн боловсруулж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 19.1.2 дахь заалтыг үндэслэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр өргөн барьсан боловч хэлэлцэгдээгүй нэг жилийн хугацаа өнгөрсөн байна.

Тогтоолын төслийг өргөн барих үед үүссэн байсан цар тахлын нөхцөл байдал өөрчлөгдөж, Өрийн удирдлагын тухай хууль болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулиудад заасан шинээр зээллэг үүсгэхтэй холбоотой зохицуулалтууд

өөрчлөгдсөн зэргээс хамааран уг тогтоолын төслийг шинэчлэх болсон анхны зорилго ач холбогдолгүй болоод байгаа учраас буцааж өгөхийг хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тогтоолын төслөө татаж байгаа юм байна. Ямар ч байсан, буцааж байгаа юм уу? Өнөөдрийн хэлэлцүүлгээс, ер нь буцааж байгаа юм уу Засгийн газар. Засгийн газраас буцаая гэж байна.

Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя юу ч гэсэн. Чимэдийн Хүрэлбаатар Эдийн засаг, хөгжлийн сайд, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Шийрэвдамбын Маргад Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын Төслийн санхүүжилтийн хэлтсийн дарга гэсэн 3 хүн ирсэн байна.

Төслийг буцаана тийм үү? Төслийг буцаая. Байж байгаарай. Асуулт байна уу? Асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй.

Ингээд санал хураалт явуулъя. Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг, буцаахыг, тогтоолын төслийг буцаах санал хураалт. Төсөл санаачлагчид нь буцааж байна. Төслийг 53 хувиар аравны, 53 хувиар дэмжиж, төслийг буцааж байна. Төсөл санаачлагчид нь буцааж байна. Өнөөдрийн, энэ чинь танилцуулах нь, танилцуулахыг нь хэлэх нь байна шүү дээ. Хэн танилцуулах юм. Эдийн засгийн байнгын хороонд тийм үү, санал хураалт явуулж дууслаа. Эдийн засгийн байнгын хороонд хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ундрам гишүүн танилцуулъя.

*Ингээд өнөөдрийн хуралдаан  
дууслаа, өндөрлөлөө.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*

